

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2018 оны 12 сарын 31-ний өдөр

Улаанбаатар хот

Архивын ерөнхий газар нь Монгол төрийн ой санамж, түүх, соёлын үнэт баримтыг хадгалан хамгаалж, өнгөрснийг одоотой, одоог ирээдүйтэй холбон, архив, албан хэрэг хөтлөлтийн тогтолцоог олон улсын стандартад нийцүүлэх эрхэм зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулж байна. Тус газар нь Хууль зүй, дотоод хэргийн сайдын А/13 дугаар тушаалаар баталсан зохион байгуулалтын бүтэц, орон тоотойгоор Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Архивын салбарын хөгжлийн стратеги” /2016-2025 он/ зэрэг бодлогын баримт бичгүүд, Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчтай байгуулсан 2018 оны үр дүнгийн гэрээ, дээд газраас ирсэн тогтоол, шийдвэр, зөвлөмж, чиглэл зэргийг холбогдох хууль дүрэм, эрх зүйн актад заасан эрх, үүргийн дагуу хэрэгжүүлж ажилласан.

Нэг. Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомж, эрх зүйн актыг боловсронгуй болгох чиглэлээр:

1. Хуулийн төсөл:

- Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн төслийг эцэслэн боловсруулж, ХЗДХЯ-нд хүргүүлсэн.

2. Засгийн газрын тогтоолын төсөл:

- 2019 онд зохион байгуулах “Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын улсын үзлэг явуулах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан танилцуулгын хамт АЕГ-ын 2018 оны 01/586 тоот албан бичгээр ХЗДХЯ-нд хүргүүлсэн.

- Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар /цаашид “ХХМТГ” гэх/-ын даргын 2017 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А-25/А-29 дүгээр хамтарсан тушаалаар байгуулагдсан “Төрийн байгууллагуудад ашиглаж байгаа архив, албан хэрэг хөтлөлтийн программ хангамжийн нөхцөл байдалд дүгнэлт өгөх, төрийн архивт хөмрөг үүсгэгч төрийн байгууллагуудад ашиглагдах архив, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг программ хангамжийн ажлын шаардлага боловсруулах” үүрэг бүхий ажлын хэсгийн дүгнэлтийн дагуу “Төрийн байгууллагуудад хэрэглэгдэх архив, албан хэрэг хөтлөлтийн программ хангамжид тавигдах нийтлэг шаардлага”-ын төслийг ХХМТГ-тай хамтран боловсруулж, ЗГ-ын 2017 оны 111 дүгээр тогтоолд нэмж оруулахаар ЗГ-ын тогтоолын төслийн хамт АЕГ-ын 2018 оны 01/582 тоот албан бичгээр ХЗДХЯ-нд хүргүүлсэн.

3. Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаал:

- “Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын байцаагчийн эрх олгох, томилох, хүчингүй болгох тухай” ХЗДХ-ийн Сайдын тушаалын төслийг боловсруулж, ХЗДХЯ-нд хүргүүлэн, батлуулсан бөгөөд эрх олгогдсон улсын байцаагчдад үнэмлэх, тэмдгийг бүртгэлийн дагуу олгосон.

- Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн А/218 дугаар тушаалаар “Архивын ерөнхий газрын бүтэц, орон тоо”-г шинэчлэн батлуулсан.

4. Агентлагийн даргын тушаал:

Тайлант хугацаанд үндсэн үйл ажиллагааны чиглэлээр 173, боловсон хүчний чиглэлээр 171, нийт **344** тушаалыг АЕГ дарга баталсан. Үүнд:

- "Архивын баримтын улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх журам"-ыг АЕГ-ын даргын 2018 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн А/76 дугаар тушаалаар;
- "АЕГ-ын хөдөлмөрийн дотоод журам"-ыг АЕГ-ын даргын 2018 оны А/110 дугаар тушаалаар;
- "АЕГ-ын оны шилдэг ажилтныг шалгаруулж, урамшуулах журам"-ыг АЕГ-ын даргын 2018 оны А/158 дугаар тушаалаар;
- "АЕГ-ын Төрийн үйлчилгээний албан хаагчийн ажлыг дүгнэх, ур чадварын нэмэгдэл олгох журам"-ыг АЕГ-ын даргын 2018 оны А/163 дугаар тушаалаар;
- АЕГ-ын дэргэдэх БНШТК-ын болон БНШАЗК-ын бүрэлдэхүүн, дүрмийг АЕГ-ын даргын 2018 оны А/138, А/139 дүгээр тушаалаар тус тус шинээр болон шинэчлэн баталсан.

5. Дараах дүрэм, журам, зааврыг төслөөр боловсруулсан:

Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын хяналтын дүрэм; Цахим хэлбэрт шилжүүлсэн кино, гэрэл зураг, дуу авианы баримтын хадгалалт, хамгаалалт, ашиглалтын журам; Төрийн архивын ажлын үндсэн заавар; Байгууллагын архивын ажлын үндсэн заавар; Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар; Зохион байгуулалт, захирамжлалын баримт бичгийн стандарт; Үндэсний төв архивт улс төрийн намуудын архивын баримтыг хүлээн авах журам; Төрийн архивын үйлчилгээний үнэ тариф; Үндэсний төв архивын уншлагын танхимаар үзүүлэх үйлчилгээний журам; Архивын зориулалтын байрны стандарт зэргийг тус тус төслөөр боловсруулсан.

Хоёр. Архивын баримтын аюулгүй байдлын баталгааг хангаж, хадгалалт хамгаалалтыг сайжруулах талаар:

1. БНСУ-ын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт олгох урт хугацаатай, хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр "АЕГ-ын шинэ цогцолбор барилгын тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангалт" төслийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан АЕГ-ын даргын 2018 оны А/106 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулж, ТЭЗҮ боловсруулах төслийн багийнхныг АЕГ-ын үндсэн үйл ажиллагаа, боловсон хүчин, барилгын бүтэц, баримтын хадгалалтын нөхцөл байдал, хадгаламжийн сангийн тоо, тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангалт зэрэг шаардлагатай судалгаа, мэдээллээр хангаж ажилласан. "Project concept paper" буюу "Төслийн үзэл баримтлал" баримт бичигт /2018.03.13-15/, "Minutes of Discussion" буюу "Хэлэлцүүлгийн тэмдэглэл" баримт бичигт /2018.12.04-05/ ХЗДХЯ, Сангийн яам, БНСУ-ын Экспорт-Импорт банкны холбогдох албан тушаалтнууд гарын үсэг зурж баталгаажуулсан.

2. Үндэсний төв архивын сан хөмрөгт хадгалагдаж буй бүх аймаг, хошуу болон албан байгууллагын тамга, захирлага, тэмдгийг тоолж, шалган, 250 тамга, 3039 тэмдэг, 148 захирлага, 422 албан бичгийн нүүр тэмдэг, гэмтэлтэй 1796 тэмдгийг ялгаж, нийт 5613 тамга, тэмдэгт бүртгэл үйлдсэн.

3. Үндэсний төв архив, Нийслэлийн архивын газар, Шүүхийн төрөлжсөн архив, Эрүүгийн хэргийн төв архив, Тагнуулын ерөнхий газрын Тусгай архив, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн мэдээллийн төвийн дарга нартай төрийн архивуудад хадгалагдаж буй баримтыг хөмрөгийн хамаарлын дагуу холбогдох архивт шилжүүлэх асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулж, гарсан саналын дагуу Үндэсний төв архиваас хөмрөгийн хамаарлаар баримт шилжүүлэх асуудлаар Улсын ерөнхий прокурорын газар, Шүүхийн ерөнхий зөвлөл, Газар зохион байгуулалт геодези, зураг зүйн газарт АЕГ-ын 2018 01/415, 01/416, 01/419 тоот албан бичгийг хүргүүлсэн. Үндэсний төв архивын Түүхийн баримтын архивын сан хөмрөгөөс Улс төрийн нам, олон нийтийн байгууллагын баримтын архивт шилжүүлэх 1921-2012 оны 32 хөмрөгийн 57 дансны 26400 хадгаламжийн нэгж баримтыг шилжүүлсэн.

4. УТА-ын Түүхийн баримтын архивын сан хөмрөгийн баримтыг түүхэн үечлэлээр ангилах ажлын төлөвлөгөө, аргачлал боловсруулан, холбогдох хөмрөгийн баримтад тооллогын ажлыг хийж дүн, илтгэх хуудсыг УТА-ын дэргэдэх ББНШАЗК-ын 5 дугаар хурлаар хэлэлцүүлсний дагуу тус архивын 19 хөмрөгийн баримтад нягтлан шалгалт, дахин боловсруулалт хийх ажлын хуваарь боловсруулж, хуваарийн дагуу 452 дугаар хөмрөгийн баримтад нягтлан шалгалт дахин боловсруулалт хийж, дансыг шинэчилсэн.

5. Төрийн архивын хосгүй үнэт баримтыг нээн илрүүлж, тэдгээрт ашиглалтын хувь үйлдэх замаар хадгалалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор төрийн архивуудын сан хөмрөгт хадгалагдаж буй баримтаас “Хосгүй үнэт баримт илрүүлэх тухай” АЕГ-ын 2018 оны 01/17 тоот албан бичгийг төрийн 37 архивт хүргүүлсэн. Үүний дагуу Гадаад харилцааны төв архивын хосгүй үнэт 21, Дундговь 18, Орхон 8, Завхан 3 баримтыг хосгүй үнэт баримтад хамруулахаар тус тус ирүүлснийг ББНШТК-ын 2018 оны 01 дүгээр хурлаар хэлэлцүүлж нийт 11 баримтыг хосгүй үнэт баримтад хамруулахаар шийдвэрлэсэн. АЕГ-аас “Хосгүй үнэт баримтыг сан хөмрөгөөс илрүүлэх, бүртгэх ажлыг гүйцэтгэх” тухай зөвлөмж боловсруулж, Төрийн архивуудад хүргүүлсэн. Үүний дагуу Үндэсний төв архивын сан хөмрөгөөс НҮБ-ын БСШУБ-ын соёлын өвд бүртгүүлэх хосгүй үнэт баримтуудыг илрүүлж, жагсаалт үйлдсэн. Архивууд жагсаалтыг Үндэсний төв архивын ББНШАЗК-ын 2018 оны 4 дүгээр хурлаар хэлэлцүүлэн батлуулсан.

6. Үндэсний төв архив, 21 аймгийн архивын тасгийн мэдээллийн санг Үндэсний дата төв дээр мэдээллийн системд холбохоор хатуу диск 2ТВ байсныг 24 ТВ, санах ой-16GB байсныг 32GB, тэжээлийн блок 2 болгож нэмэгдүүлсэн. Одоогийн байдлаар 21 аймгийн архивын тасгийн Төрийн архивын баримтын бүртгэлийн “AMS” программын 31GB хэмжээ бүхий мэдээллийн сангийн файлуудыг /MSSQL серверийн .mdf/ Үндэсний дата төв дээрх серверт байршуулан нөөцөлсөн.

7. Үндэсний төв архивт иж бүрэн компьютер 3ш, өнгөт принтер 1ш, хувилагч 1ш, ухаалаг дэлгэц 1ш, серверийн 8ш хард диск, 8ш санах ой, 24ТВ хэмжээтэй хадгалах төхөөрөмж зэргийг АЕГ-ын 2018 оны төсвийн урсгал зардлын санхүүжилтээр худалдан авсан. 2018 онд Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын санхүүжилтээр тус аймгийн Архивын тасагт иж бүрэн 2 компьютер авч, баримтыг цахимжуулах ажлыг хийж байна. Дархан-Уул аймгийн Архивын тасагт ЗДТГ-ын санхүүжилтээр өндөр хүчин чадалтай сканер худалдан авах асуудлыг шийдвэрлэсэн.

8. АЕГ-ын байранд ариутгал хийгдэх шаардлагатай ажлын өрөө, хадгаламжийн сан, бусад талбайн хэмжээг тооцож гарган, ариутгал халдваргүйжүүлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг мэргэжлийн 8 байгууллагын ажлын туршлага, хэрэглэж буй хор, урвалж бодис, үйлчилгээний төлбөрийн санал зэргийг судалсны үндсэн дээр “РББО-сервис” ХХК-ийг сонгож, 2018 оны 05 дугаар сарын 07-ны өдөр гэрээ байгуулж, 2018 оны 05 дугаар сарын 11, 09 дүгээр сарын 28-ны өдөр архивын байранд хортон шавьж, мэрэгчийн ариутгал, халдваргүйтгэл, устгалын ажлыг хийлгэсэн. Хадгалалтын технологич ажлын явцад хяналт тавьж ажилласан бөгөөд гүйцэтгэлийг актаар хүлээн авсан. АЕГ-ын байрны зоорийн давхарт мэрэгч илэрсэнтэй холбогдуулан 2018 оны 08 дугаар сарын 01, 10 дугаар сарын 25-ны өдөр АЕГ-ын байрны I давхар, зоорийн хэсэгт мэрэгчийн хор тавьсан.

Гурав. Архивын баримтыг цахимжуулах хүрээнд:

1. Үндэсний төв архив, аймгуудын төрийн архивт 2018 онд 15900 хадгаламжийн нэгжид, сэдэвчилсэн боловсруулалт хийж, программд холбоно. 2018 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар 28161 /Аймгуудын архивт 26490, Үндэсний төв архивт 1671/ хадгаламжийн нэгжид сэдэвчилсэн боловсруулалт хийж программд холбосон.

2. Үндэсний төв архив, 21 аймгийн төрийн архивт цахим хэлбэрт шилжүүлэх шаардлагатай нийт баримтын 30%-ийг буюу 2018 онд 16683 хадгаламжийн нэгжийг цахим хэлбэрт шилжүүлнэ. 2018 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар 16734 /Аймгуудын архивт 14380, Үндэсний төв архивт 2185, Цагдаа, БХТА-т 169/ хадгаламжийн нэгжийг буюу 30,09%-ийг цахим хэлбэрт шилжүүлсэн.

3. Кино, гэрэл зураг, дуу авианы баримтын архивт хадгалагдаж буй 35 мм-ийн хальсан дээрх 39 нэрийн баримтат, 30 нэрийн орчуулгын уран сайхны киног позитив хальснаас цахим хэлбэр /HD формат/-т хөрвүүлэн серверт хуулсан. Цахим хэлбэрт

шилжүүлэх гэрэл зургийг сэдвийн дагуу ангилан, жагсаалт үйлдэж, 15000 хадгаламжийн нэгж баримтыг шилэн болон хальсан негативаас 1200 DPI нягтралтайгаар мастер хувь, 300 DPI нягтралтайгаар ашиглалтын хувь үүсгэн цахим хэлбэрт шилжүүлсэн.

4. Үндэсний төв архивын сан хөмрөг дэх Монгол Улсын хүн амын 1989 оны тооллогын баримтаар цахим мэдээллийн сан үүсгэж дууссан ба 813 хадгаламжийн нэгж баримтын 518304 хүний мэдээллийг программд оруулсан.

5. Үндэсний төв архивт баримт нь хадгалагдаж буй 10 байгууллагын 1671 хадгаламжийн нэгжийн 267820 хуудсыг цахим хэлбэрт шилжүүлж, лавлагаа, үйлчилгээнд ашиглаж байна.

6. Баримтыг цахимжуулах ажилд тавигдах арга зүйн чиглэлийг тодорхойлсон “Цахим архивын баримт бүрдүүлэлт, данс, бүртгэл үйлдэх арга зүй” онол арга зүйн 91 хуудас, 12 хэвлэлийн хуудас арга зүйн ном бичиж хэвлүүлэн нийт төрийн архивуудад хүргүүлсэн.

7. Монгол Улсын 2000 оны хүн ам, орон сууцны тооллогын баримтаас 2371 хадгаламжийн нэгжийн 2114407 хүний мэдээллийг цахим хувьтай нь тулгаж баталгаажуулсан.

8. Улс төрийн нам, олон нийтийн байгууллагын баримтын архивын сан хөмрөгөөс 19 нэр төрлийн 86 багц сонины 16930 хуудас баримтыг сканердаж ашиглалтын хувь үүсгэсэн.

9. 1981-1989 оны МАХН-ын Улс төрийн товчооны, Сайд нарын Зөвлөлийн хамтарсан хурлын 452 тогтоолын 1992 хуудас баримтыг сканердаж, photoshop программд оруулан засварлаж, эх баримттай холбон лавлагаанд ашиглаж байна.

10. Лавлагаанд гарсан МАХН-ын гишүүний бүртгэх хуудаснаас 20 үсгийн нийт 537 ширхэг бүртгэх хуудсыг тоон мэдээллийн санд шивж оруулсан. Намын гишүүний 9 үсгийн 11 хавтаст хэргийн 351 хүний овог нэрийг AMS программд шивж оруулсан.

11. Негативгүй 50 ширхэг цомгийн нийт 2036 ширхэг гэрэл зургийг хуулбарлаж, хадгалалтын болон ашиглалтын хувь үүсгэсэн.

12. УИХ, ХЭҮК, МХЕГ, НХҮЕГ, ТаЕГ, ТЕГ, УДШ, ХАБЭМТ, ШШГБ, ЭМНДЕГ-ын DVD тээгчтэй баримтаас 1997-2004 оны 1141 хадгаламжийн нэгжийг хуулж цахим хувь үүсгэсэн.

13. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын “Аудио кассет” тээгчтэй 14 хадгаламжийн нэгж буюу 14 цаг 56 минутын бичлэгийг хуулж цахим мэдээллийн санд оруулсан.

Дөрөв. Нөхөн бүрдүүлэлтийн чиглэлээр:

1. Үндэсний төв архивын сан хөмрөгийг 37 байгууллага, 3 хувийн хөмрөгийн 1501-2018 оны 15079 хадгаламжийн нэгж, кино мэдээ 11 дугаар, 22 бүлэг кино хальс, 5508 ширхэг гэрэл зургаар нөхөн бүрдүүлэлт хийсэн.

2. Шинээр ашиглалтад хүлээж авсан 543 объект /давхардсан тоогоор/-ын 5799 хавтаст хэрэг бүхий зураг төсөл, техникийн баримтыг шилжүүлэн авч зохих журмын дагуу акт үйлдэн сан хөмрөгөө нөхөн баяжуулсан.

Тав. Сэлбэн засах сэргээн шинэтгэх чиглэлээр:

Үндэсний төв архивын 4 архивын сан хөмрөгөөс нийтдээ 66 хөмрөгийн 1039 хадгаламжийн нэгжийн 2829 нугалбар бичиг, 55 ширхэг барилгын зураг, 24448 хуудас баримт, 190 хайрцаг, 173 дэлгэмэл хавтас, 5 ширхэг гэрэл зургийн цомог сэргээн засварлаж, 2171 хадгаламжийн нэгж үдэж хавтасласан. Шинээр 100 хайрцаг, 100 дугтуй хийж, сан хөмрөгт шилжүүлсэн.

Зургаа. Эрдэм шинжилгээ, техник боловсруулалт, нягтлан шалгалт ажлын хүрээнд:

1. Кино, гэрэл зураг дуу авианы баримтын архивын сан хөмрөгөөс:

- Монголын хүүхэлдэйн театрын 6,25 мм-ийн соронзон бичлэгийн 57 хадгаламжийн нэгж, “Кино миний амьдрал” Үндэсний кино урлаг үүсэж хөгжсөний 80 жилийн ой, КУДС-ийн 20 жилийн ойд зориулан бүтээсэн уран бүтээлчдийн хөрөг нэвтрүүлэг болох 77 дугаарт;

- Нөхөн бүрдүүлэлтээр хүлээн авсан нийт 42 бүлэг кино баримтад;

- “Намуун Зэт” продакшны бүтээл 30 нэрийн баримтат кино баримтад;
- “Цэвэр агаар сан” төслийн 99 хадгаламжийн нэгж DVD тээгчтэй баримтад;
- Архивын нүүлгэлт болон архивын 90 жилийн ойн хүрээнд зохиогдсон арга хэмжээний 328 ширхэг гэрэл зураг;

- “Монгол кино” нэгтгэлээс нөхөн бүрдүүлэлтээр хүлээн авсан “Түүхийн хүрд” кино мэдээ, сэтгүүлийн 2016 оны №1-12, 2017 оны №1-11, 2018 оны №1, 2, 3-р дугаарт ЭШТБ, нягтлан шалгалтын ажил хийсэн.

2. Зураг төслийн баримтын архивын сан хөмрөгөөс:

- 2014-2017 онд улсын комиссоор ашиглалтанд хүлээн авсан объектоос Сонгинохайрхан, Сүхбаатар, Чингэлтэй, Багануур, Налайх дүүрэгт баригдсан орон сууцны барилга байгууламжийн зураг төсөл бүхий 1692 хавтаст хэргээс түүвэрлэн, нийт 99 объектын 1848 хадгаламжийн нэгжид;

- 2014-2016 онд улсын комиссоор ашиглалтанд хүлээн авсан объектоос Баянгол, Баянзүрх дүүрэгт баригдсан орон сууцны барилга байгууламжийн зураг төсөл бүхий 1225 хавтаст хэргээс түүвэрлэн, нийт 56 объектын 1637 хадгаламжийн нэгжид ЭШТБ, нягтлан шалгалтын ажил хийсэн.

3. Түүхийн баримтын архивын сан хөмрөгөөс:

11 байгууллага, 2 хувийн хөмрөгийн 1501-2017 оны 5422 хадгаламжийн нэгжид эрдэм шинжилгээ техник боловсруулалт, нягтлан шалгалтын ажил хийсэн. Үүнд:

- “Монгол-Эрдэнэ” ХК 1986-999 оны 160;
- Тахарын ерөнхий газар 2014-2016 оны 1744;
- Үндэсний мэдээллийн МОНЦАМЭ агентлаг 1958-2002 оны 122;
- Монголын үндэсний түүхийн музей 1991-2005 оны 194;
- Засгийн газрын мэдээ сонин 1991-1998 оны 16;
- Хүний гавьяат эмч, доктор, профессор Маналжавын Шагдарсүрэнгийн хувийн хөмрөг 1996-2017 оны 19;
- Аж үйлдвэрийн яам 1930-1951 оны 487;
- ШУ-ны гавьяат зүтгэлтэн доктор, профессор Аюудайн Очирын хувийн хөмрөг 1501-2017 оны 246;
- Соёл, спорт, аялал жуулчлалын яамны 2012-2014 оны 915;
- Үндэсний архивын газар 1927-2005 оны 1270;
- Хортон мэрэгчтэй тэмцэх товчооны 1976-1998 оны 96;
- Гэмтэл согог сэргээн засварлах клиникийн эмнэлгийн 1974-1980 оны 7;
- Байгаль орчны яамны 1989-2002 оны 146 хадгаламжийн нэгжид ЭШТБ, нягтлан шалгалтын ажил хийсэн.

4. Улс төрийн нам, олон нийтийн байгууллагын баримтын архивын сан хөмрөгөөс:

2018 онд нийт 6531 хадгаламжийн нэгжид ЭШТБ, нягтлан шалгалт ажил хийгдсэн. Үүнд:

- Намын хянан шалгах хорооны дарга Б.Дэжидэд иргэдээс ирүүлсэн захидлууд 1981-1990 оны 115;
- Сан хөмрөгт хадгалагдаж байгаа 21 нэр төрлийн сонины 783;
- “Дэлхийн зөн” ОУ-ын байгууллагын 1996-2017 оны 2698;
- Хөмрөг 166 буюу намын гишүүний хувийн хэргийн 2935 хадгаламжийн нэгж байна.

Долоо. Архивын баримтын тоо бүртгэл ажлын хүрээнд:

1. Зураг төслийн баримтын архивын сан хөмрөгийн:

- Хөмрөг №26-ын данс №2-3, 9-2, 9-3-ыг УТА-ын дэргэдэх ББНШАЗК-ын 2018 оны 3, 4 дүгээр хурлаар хэлэлцүүлж батлуулсан.

- Хөмрөг №22-ын данс №1-5-ын 3983 хадгаламжийн нэгжийг тоолж, шалган хадгаламжийн нэгжийн баталгааны хэсэгт тэмдэглэл хөтлөн, тооллогын хуудас, тоолж шалгасан тухай акт үйлдсэн.

2. Түүхийн баримтын архивын сан хөмрөгийн:

- Тооллогын явцад зөрчил илэрсэн их засвартай шинэчлэх шаардлагатай 74 хөмрөгийн 108 данс, 11 бүртгэлийг шинэчлэн шивж, үдэж хавтаслав.

- Төрийн архивуудад шилжүүлэх баримтад хийх тооллогын хуваарийн дагуу 46 хөмрөгийн 83 данс, 8 бүртгэлийн 1921-2012 оны 31089 хн-ийг данс, бүртгэлтэй нь тулган хадгаламжийн нэгжээр нь тоолж шалган, тооллогын акт, хуудас бичиж, тоо бүртгэлийн баримт бичигт өөрчлөлт хөдөлгөөн хийлээ.

- “Архивын баримтын улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх журам”-ын 3.1.1-д заасны дагуу ТБА-т хөмрөг үүсгэгч 175 байгууллагад албан бичиг явуулснаас албан бичгээр 131 байгууллагын архивын баримтын бүрэлдэхүүн, тоо хэмжээ, хадгалалтын мэдээг хүлээн авч, 131 байгууллагын мэдээг тус бүрээр нь Тоо бүртгэлийн программд шивж оруулав. Мөн журмын 3.2.1-д заасны дагуу ТБА-ын баримтын бүрэлдэхүүн, тоо хэмжээ, хадгалалтын мэдээг нэгтгэн гаргаж, Тоо бүртгэлийн программд шивж орууллаа. Эдгээр мэдээг журамд заасан хугацаанд буюу 2017 оны 02 дугаар сарын 14-ний өдөр АЕГ-ын МАЗУГ-т хүргүүлэв.

3. Улс төрийн нам, олон нийтийн байгууллагын баримтын архивын сан хөмрөгийн:

- Цуглуулга хөмрөг №5, данс 1-ийн 81 хадгаламжийн нэгжийн 9757 хуудас, цуглуулга хөмрөг №6, данс 1-ийн 174 хадгаламжийн нэгжийн 23104 хуудас, цуглуулга хөмрөг №7, данс 1-ийн 81 хадгаламжийн 6987 хуудас, нийт 3 хөмрөгийн 336 хадгаламжийн 39848 хуудас тоолж, тооллого хийсэн.

Найм. Лавлагаа, үйлчилгээний чиглэлээр:

1. 12976 иргэн, байгууллагын захиалгын дагуу 216509 хадгаламжийн нэгж ашиглалтад гаргаж, архивын лавлагаа, хуулбар, 2215 минутын дүрс бичлэг, 233 бүлэг баримтат кино, 2216 ширхэг гэрэл зураг, 1600 минутын дуу авиа, 32814 хуудас барилгын зураг төсөл бүхий техникийн баримт бичгийн хуулбарыг олгосон. Архивын лавлагаа, хуулбарын төлбөрөөр 93151400 төгрөгний орлогыг төрийн санд оруулсан.

2. Онлайн лавлагааны дагуу 130 иргэний хүсэлт захиалгыг шийдвэрлэсэн.

3. Уншлагын танхимаар 1429 судлаач, иргэн, байгууллагад /давхардсан тоогоор/ цаасан 295 хөмрөгийн 16812 хадгаламжийн нэгж, цахим 295 хөмрөгийн 1886 хадгаламжийн нэгж, 119 сонин, 38 сэтгүүл, 26 ном, намын гишүүний бүртгэх хуудас 132, хувийн хэрэг 138-ыг ашиглалтад гаргаж, баримтын ашиглалтын хуудас хөтөлсөн. Судалгааны болон хуулбарын төлбөрөөр 16780500 төгрөгний орлогыг төрийн санд оруулсан.

4. АЕГ-ын “1800-1205” Архивын лавлах утсаар нийт 2761 иргэн, байгууллагад архивын мэдээлэл өгсөн.

5. 542 байгууллагын захиалгын дагуу 556 хэвлэмэл хуудасны эхийг шинээр болон дахин бэлтгэж, А4 531982, А5 490608 ширхэг хэвлэмэл хуудсыг хэвлэж, холбогдох байгууллагад хүргүүлсэн.

6. Архивын ерөнхий газрын Улсын хяналтын байцаагч, мэргэжилтэн, зааварлагч, арга зүйч нар архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр 1040 иргэн байгууллагад арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

7. Архивын ерөнхий газраас үзүүлж буй үйлчилгээг иргэд нэг дороос хүндрэл чирэгдэлгүй авах нөхцөлийг бүрдүүлэх, үйлчлүүлэгчдэд тав тухтай орчныг бий болгох зорилгоор Архивын ерөнхий газрын нэг цэгийн үйлчилгээний танхимыг шинэчлэн тохижуулж “Лавлагаа үйлчилгээний төв” нэртэйгээр 2018 оны 11 дүгээр сарын 29-нд нээсэн. Энэ хүрээнд дараах ажлуудыг хийж хэрэгжүүлсэн:

- Архивын лавлах утас 1800-1205 дугаарын утсыг Лавлагаа, үйлчилгээний танхимд байршуулан утгах үйлчилгээг хамтатган бий болгосон;

- Мэдрэгчтэй хоёр дэлгэц байршуулан Үндэсний төв архивын сан хөмрөгт хадгалагдаж буй баримтын жагсаалтыг харах, байгууллагын вэб сайтад хандаж мэдээлэл авах боломжоор хангасан;

- Үйлчилгээний танхимд байршуулсан дэлгэцээр байгууллагын үйл ажиллагааг сурталчилсан видео шторкыг гаргаж, 7 хоног тутам видео мэдээллийг шинэчлэн иргэдэд мэдээлэл хүргэж байна;

- АЕГ-аас үзүүлж буй үйлчилгээний талаарх танилцуулга брошурыг иргэдэд ойлгомжтой байдлаар бэлтгэж Лавлагаа, үйлчилгээний төвд байршуулсан;

- Үүний зэрэгцээ үйлчилгээний албан хаагчдын цайны цагт зохицуулалт хийж, 08:30-17:00 цагийн хооронд иргэн, байгууллага, судлаачдад тасралтгүй үйлчилж эхэлсэн.
- Төрийн үйлчилгээг иргэд, олон нийтэд хүртээмжтэй хүргэх талаас нь анхаарахаас гадна уг үйлчилгээг олон нийтэд хүргэж буй үйлчилгээний ажилтнуудынхаа ур чадварыг дээшлүүлэх, харилцагч үйлчлүүлэгчтэй зохистой харилцах, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг бий болгоход чиглэсэн сургалтад хамруулж, үйлчилгээний албан хаагчдын дүрэмт хувцсыг шинэчилсэн.

Ес. Архивын баримт, байгууллагын үйл ажиллагааг сурталчлах чиглэлээр:

1. “Монгол-Оросын эдийн засгийн харилцаа” сэдэвт архивын баримт, гэрэл зургийн үзэсгэлэнг АЕГ-ын үзэсгэлэнгийн танхимд 2018 оны 06 дугаар сарын 19-ний өдрөөс 2018 оны 07 дугаар сарын 10-ны өдрүүдэд дэлгэж, иргэд, олон нийтэд үнэ төлбөргүйгээр үзүүлсэн.
2. Дэлхийн дуу дүрсний өвийн өдөрт зориулан “Мандухай сэцэн хатан кино дэлгэцнээ гарсны 30 жил” баримт бичиг, гэрэл зураг, биет үзмэрийн үзэсгэлэнг 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдөр АЕГ-ын үзэсгэлэнгийн танхимд зохион байгуулсан.
3. 2018 оны 12 дугаар сарын 05-аас 07-ны өдрүүдэд Монголын Үндэсний музей, БНФУ-ын Элчин Сайдын Яам, Гадаад харилцааны яамтай хамтран “Монгол, Францын харилцаа: Эрт эдүгээ” сэдэвт түүхэн баримт, гэрэл зургийн үзэсгэлэнг зохион байгуулсан.
4. Сайн ноён хан Т.Намнансүрэнгийн 140 жилийн ойд зориулсан архивын баримт, гэрэл зургийн үзэсгэлэнг 2018 оны 12 дугаар сарын 10-21-ний өдрүүдэд Үндэсний түүхийн музейд зохион байгуулсан.
5. Баян-Өлгий аймгийн Архивын тасагт хадгалагдаж буй баримт, гэрэл зургуудыг 2018 оны 03 дугаар сарын 27-нд, 09 дүгээр сарын 30-ны өдөр “Монгол-Зөвлөлтийн эдийн засгийн харилцаа /1955-1985 он/” сэдэвт үзэсгэлэнгийн гэрэл зургууд, 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр Ховд, Булган аймгийн архивын тасагт хадгалагдаж буй гэрэл зургийн баримтуудаас тайлбарын хамт байгууллагын цахим хуудсанд байршуулсан байна.
6. Амарсанаа” (1750-1774) баримт бичгийн эмхэтгэлийг Түүх соёл, хэл бичиг судлалын “Тод номын гэрэл” төвтэй хамтран 18,3 хэвлэлийн хуудастай хэвлүүлсэн.
7. Монгол Улсад орчин цагийн архивын алба үүсэж хөгжсөний 90 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийг эмхэтгэж, “Монгол Улсын Архивын албаны үүсэл, хөгжил: уламжлал, шинэчлэл-90 жил” /21 х.х/ номыг бэлтгэж хэвлүүлсэн.
8. “Архивын мэдээлэл” сэтгүүлийн 16 дугаар дугаарыг бэлтгэж хэвлүүлсэн.
9. Үндэсний төв архивын сан хөмрөг дэх Ноёд, тайж, лам нарын захидлын цуглуулга /М170/ хөмрөгөөс 312 хадгаламжийн нэгжийн 3269 баримтын агуулгыг уйгаржин монгол бичгээс кирилл бичиг рүү хөрвүүлж, “Ноёд, тайж, лам нарын захидлын цуглуулга хөмрөгийн дээжис” баримтын эмхэтгэлд оруулахаар 560 хуудас баримтыг сонгон бүрэн эхээр нь хөрвүүлсэн ба хөрвүүлгийг эх баримттай нь тулгах, хүн, газар орон, байгууллагын нэрийн индекс бэлтгэх ажил хийгдэж, А4 хэмжээтэй 450 хуудас бүхий хэвлэлийн эх бэлтгэсэн.
10. ШУА, Түүх, археологийн хүрээлэнд Үндэсний төв архивын сан хөмрөг дэх Манжийн үеийн хөмрөгийн 10 данснаас “Манж Чин улсын үеийн Монголын тамгатай хутагтууд, сүм хийдийн талаарх” баримтын эмхэтгэлд орох 30 гаруй баримт бэлтгэж өгсөн.
11. Түүх, археологийн хүрээлэн, Үндэсний номын сантай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд “Торгон дээрх баримтын гэрэл зургийн цомог” хамтран хийхээр төлөвлөсний дагуу Үндэсний төв архивын Түүхийн баримтын архивт хадгалагдаж буй торго болон даавуун суурьтай 130 баримтын жагсаалтыг гаргасан.
12. “Монголын тухай БХК (б) Н-ын баримт бичиг” баримт бичгийн эмхэтгэлийн /1953-1966/ IV ботид оруулах баримтыг Үндэсний төв архивын баримтын сан хөмрөгөөс сонгох ажил үргэлжлэн хийгдэж байна. Номын төлөвлөгөө концепцыг эцэслэн боловсруулж, бэлэн болгосны гадна Оросын талд энэ тухай саналаа албан ёсоор хүргүүлэхээр бэлтгэв. Эмхэтгэлийн сэдэвт холбогдох баримтын судалгааг Улс төрийн нам, олон нийтийн байгууллагын баримтын архив болон Гадаад харилцааны төв архивт эхлүүлсэн.
13. Үндэсний төв архивын сан хөмрөгт хадгалагдаж буй Дорно дахины хүрээлэн буюу одоогийн Олон улс судлалын хүрээлэнгийн захирлаар ажиллаж байсан академич

Н.Ишжамцын хувийн хөмрөгөөс “1956 онд Монгол Улсын түүхэнд холбогдох баримт материал олох, судлах ажлаар БНХАУ-д 6 сар гаруй ажилласан тухай” тайлан илтгэлийг олж, сийрүүлж, холбогдох тайлбар, зүүлтийг хийж, тус хүрээлэн байгуулагдсаны 50 жилийн ойд зориулж гарах эрдэм шинжилгээний ном, сэтгүүлд нийтлүүлэхээр А-4, 16 хуудас материал өгсөн.

14. Монгол Улсын төрийн нэрт зүтгэлтэн, анхны Ерөнхий сайд Түмэнхэн номун эзэн, Итгэмжит зетэй, Эрх дайчин Сайн ноён хан Т.Намнансүрэнгийн мэлмий гийсний 140 жилийн ойд зориулсан “Монгол Улсын анхны Ерөнхий сайд Сайн ноён хан Т.Намнансүрэн -140” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдөр Түүх, археологийн хүрээлэнтэй хамтран Шинжлэх ухааны академийн Тэргүүлэгчдийн газарт зохион байгуулсан.

15. Архивын ерөнхий газар нь Ийгл телевиз, МҮОНРТ-тэй хамтран ажиллах гэрээтэй ажиллаж байгаа бөгөөд байгууллагын хэмжээнд хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагааг тухай бүр хамтран ажиллах гэрээтэй 2 телевиз болон олон нийт, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж ажилласан. Мөн “Мэдээллийн ил тод байдал ба мэдээллийн авах эрхийн тухай хууль”-д заасан мэдээллийг байгууллагын цахим хуудсанд тухай бүр байршуулж ажилласан.

16. Тэмдэглэлт өдрүүдээр Үндэсний төв архивын сан хөмрөгийн баримтаас тухайн өдөртэй холбогдох баримтыг илрүүлж байгууллагын цахим хуудсанд дараах мэдээ, мэдээллийг нийтэлсэн. Үүнд: Үндсэн хуулийн өдөр /2018.01.22-нд/, Жанжин Д.Сүхбаатарын мэндэлсэн өдөр /2018.02.02/, Цагаан сарыг тэмдэглэх тухай /2018.02.25-нд/, Монгол Улс олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэх болсон тухай /2018.03.07-нд/, Гал түймэртэй тэмцэх албаны тухай өгүүлэхүй /2018.03.17-нд/, Монгол Улсын “Сансрын нисгэгч” цол тэмдгийн тухай /2018.03.22-нд/, Эх үрсийн баяр ба ихэр хүүхдүүдийг дэмжих бодлого /2018.06.01-нд/, Улсын Их баяр наадмын мэндчилгээ /2018.07.10-нд/, Өнөөдөр харилцаа холбоо, мэдээллийн технологийн өдөр /2018.07.24/, Зарим улс орны хичээлийн шинэ жилийн онцлогоос /2018.09.01/, Монголчуудын бичиг үсгийн хөгжил ба Кирилл үсгийн уламжлал /2018.09.02/, Их Барилга-Ирээдүйн хөгжлийн түүхээ /2018.09.07/, Өнөөдөр багш нарын баярын өдөрт зориулсан архивын баримтын мэдээ /2018.10.05/, “Монгол Улс ба Нэгдсэн үндэстний байгууллага” /2018.10.24/, “Монгол Улсад үндэсний кино урлаг үүсгэн байгуулах тухай архивын баримтын мэдээ” /2018.10.27-нд/, “Монгол бахархлын өдөр”-г зориулсан Үндэсний төв архивын баримт материалаар мэдээ /2018.11.08/ сэдвээр нийт 16 мэдээ хүргэсэн.

Арав. Архивын салбарын гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр:

Гадаад харилцаа, хамтын ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэн ажилласан.

1. Архивын салбарт хамтран ажиллах “Монгол-Оросын Засгийн газар хоорондын хамтарсан комиссын XXIII хуралдааны товыг ОХУ-ын Архивын асуудал эрхэлсэн Засгийн газрын агентлагтай зөвшилцөн гаргаж хурлыг 2018 оны 06 дугаар сарын 19-23-ны өдрүүдэд Эрдэнэт хотод зохион байгуулсан.

2. 2018 оны 11 дүгээр сарын 05-09-ний өдрүүдэд БНХАУ-ын Фужоу мужид зохион байгуулагдсан Олон улсын архивын зөвлөлийн Зүүн азийн бүсийн салбар зөвлөлийн хуралдаанд АЕГ-аас 2 албан хаагч оролцож, “Монгол Улсын Үндэсний төв архивт хадгалагдаж байгаа цайны замд холбогдох баримтат өв” сэдвээр илтгэл тавьсан.

3. Бүгд найрамдах Киргиз улсын Засгийн газрын харьяа Улсын бүртгэлийн албаны архивын агентлагтай байгуулах “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн төслийг орос монгол хэл дээр боловсруулж, ХЗДХЯ, ГХЯ-аар хянуулж, гэрээ байгуулах зөвшөөрөл авсан.

4. Япон улсын Үндэсний архивын газартай Хамтын ажиллагааны санамж бичиг байгуулахаар төслийг эцэслэн тохирсон.

5. Япон улсын Үндэсний угсаатны зүйн музейн урилгаар АЕГ-ын дарга 2 албан хаагчийн хамт 2018 оны 11 дүгээр сарын 02-07-ны өдрүүдэд Япон улсад албан айлчлал хийж, Токио хотноо Олон улсын Монгол судлалын холбооноос зохион байгуулсан “ХХ зууны Монголын ертөнц: эргэн харах нь” сэдэвт олон улсын хуралд оролцохын зэрэгцээ

сэлбэн засах, сэргээн шинэтгэх болон тусгай төрлийн тээгчтэй баримтыг сэргээн засварлах, хадгалах талаар туршлага судалсан.

6. 2018 оны 12 дугаар сарын 27-31-ний өдрүүдэд 2 албан хаагч Хонконгийн архивын байгууллагын үйл ажиллагаатай танилцаж, туршлага судалсан.

Арван нэг. Мэдээллийн технологийн чиглэлээр:

1. Үндэсний статистикийн хороотой “Хүн ам, орон сууцны 1933, 1944, 2010 оны улсын тооллогын цахим мэдээллийн санг харилцан хүлээлгэн өгөх гэрээ” байгуулан, мэдээллийн сангийн баазыг шилжүүлэн авсан. “Монгол Улсын 2010 оны хүн амын тооллогын тоо бүртгэл, хяналтын программ”-ыг боловсруулсан.

2. Монгол Улсын хүн амын 1989, 2000 оны тооллогын тоо бүртгэлийн программын хайлтын хэсэгт нэмэлт сайжруулалтыг хийсэн. Мөн хяналтын хэсгийг боловсруулж 2018 оны 03 дугаар сарын 16-ны өдрөөс Үндэсний төв архивын Цахим сангийн төвийн үйл ажиллагаанд нэвтрүүлэн ашиглаж байна.

3. “Архивын баримтын улсын нэгдсэн тоо бүртгэл-мэдээллийн сан”-ийн программ хангамжийг “Колпро” компанитай хамтран боловсруулж, хөмрөг үүсгэгч байгууллагуудад нэвтрүүлсэн.

4. Монгол Улсын 1989, 2000 оны хүн амын тооллогын өгөгдлийн сан, AMS data өгөгдлийн санг автоматаар нөөцлөх программ суулгаж, өдөр бүр 22 цагт өгөгдлийн санг нөөцлөх тохиргоог хийсэн.

5. “Үнэн” сонины цахим хувийн ашиглалтын программыг боловсруулсан.

Арван хоёр. Салбарын болон байгууллагын боловсон хүчнийг сургах, мэргэшүүлэх чиглэлээр:

1. ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны 05 дугаар сарын 07-ны өдөр баталсан “Эрх зүйн сургалт, сурталчилгааны чиглэлээр 2018 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө”-нд заасны дагуу “Архив, албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомжийг байгууллага болон төрийн архивын үйл ажиллагаанд хэрэгжүүлэхэд анхаарах асуудлууд”, “Баримт бичиг зохион бүрдүүлэхэд тавигдах үндсэн шаардлага, анхаарах асуудлууд”, /MNS5140:2011/, “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4, 5, 11 дүгээр заалт болон Засгийн газрын 2017 оны 04 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэн ажиллахад анхаарах асуудлууд” сэдвүүдээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Тагнуулын ерөнхий газар, Кибер аюулгүй байдлын газрын холбогдох ажилтнуудтай зөвшилцөж, онлайн (дүрст) сургалтыг ЗГХЭГ-ын Нутгийн удирдлагын танхимд 05 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулсан. Сургалтад аймаг, нийслэлийн ЗДТГ-ын дарга, орон нутгийн байгууллагын дарга нар нийт 200 орчим албан хаагч хамрагдсан.

2. Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын байцаагчдын зөвлөгөөнийг 2018 оны 07 дугаар сарын 18-20-ны өдрүүдэд зохион байгуулсан. Зөвлөгөөнөөр ХЗДХЯ, Улсын ерөнхий прокурорын газар, Нийслэлийн прокурорын газар, Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүх, Тагнуулын ерөнхий газар, Авлигатай тэмцэх газар, Удирдлагын академи зэрэг байгууллагуудтай хамтран ажиллаж Захиргааны шийдвэр гаргах ажиллагаан дахь нийтлэг алдаа, түүнээс сэргийлэх арга зам, Шийтгэлийн хуудас түүнийг хэрэглэх тухай, Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд гарсан зөрчил шалган шийдвэрлэхэд анхаарах асуудал, зөвлөмж, Зөрчлийн хэргийн хувийн хэрэг бүрдүүлэх арга зүйн асуудлуудаар хичээл заалгаж, иргэдийн эрхийг зөрчихгүй байх талаар улсын байцаагчдад мэдээлэл, мэдлэг олгосон.

3. Төрийн архивын удирдах ажилтны нэгдсэн зөвлөгөөнийг 4 дүгээр сарын 19-20-ны өдрүүдэд зохион байгуулсан.

4. Төв, төрөлжсөн архивын дарга, архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын улсын байцаагч нарт Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран “Хаягжуулалт, бүсчлэлийн код”-ын талаар сургалт зохион байгуулсан.

5. 2018 онд Архивын ерөнхий газрын сургалтын төвд “Архив, албан хэрэг хөтлөлтийн онол, арга зүй”, “Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу хэрэг бүрдүүлэх, баримтад эрдэм шинжилгээ, техник боловсруулалт хийх ажлын арга зүй”, “Төрийн

архивын баримтад иж бүрэн нягтлан шалгалт, дахин боловсруулалт хийх, данс, бүртгэл үйлдэх ажлын арга зүй”, “Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх ажлын арга зүй”, “Баримт бичгийн стандарт, баримт бичгийг зохион бүрдүүлэх арга зүй”, “Байгууллагын архивын баримтад эрдэм шинжилгээ, техник боловсруулалт хийх, нөхөн бүрдүүлэлтээр баримт хүлээн авах ажлын арга зүй”, “Баримтын үнэ цэнийг нягтлан шалгах, данс, бүртгэл, акт үйлдэх ажлын арга зүй”, “Сэлбэн засах, сэргээн шинэтгэх ажлын технологи нэвтрүүлэх ажлын арга зүй” зэрэг сэдвүүдээр анхан шатны 8, мэргэшүүлэх 9, захиалгат 5 удаагийн сургалт зохион байгуулж, анхан шатанд 417 хүн, мэргэшүүлэхэд 437 хүн, захиалгат сургалтад 167 нийт 1021 хүн суралцаж төгссөн.

6. Баян-Өлгий аймгийн ЗДТГ-тай хамтран 2018 оны 10 сарын 01-12-ны өдрүүдэд тус аймгийн төвийн болон сумдын төрийн байгууллагын 76 ажилтанд архив, албан хэрэг хөтлөлтийн сургалт зохион байгуулж, уг сургалтад хамрагдсан ажилтнуудад АЕГ-ын даргын 2018 оны А/126 дугаар тушаалаар “Мэргэжлийн үнэмлэх” олгосон.

7. Архивын ерөнхий газрын албан хаагчдын 2018 оны сургалтын төлөвлөгөөг АЕГ-ын даргын 2018 оны А/8 дугаар тушаалаар батлуулж, төлөвлөгөөний дагуу “Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа, хандлага”, “Үйлчилгээний ажилтнуудын үйлчилгээ үзүүлэх ур чадвар, харилцаа”, “Гамшгаас хамгаалах болон галын аюулаас урьдчилан сэргийлэх”, “Төрийн болон албаны нууцын тухай хуулийн үзэл баримтлал, онцлог”, “Төрийн албаны тухай” /Шинэчилсэн найруулга/ хуулийн талаар, “Хүүхдийн эрх ба бизнесийн зарчим болон холбогдох хууль тогтоомж”, “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” зэрэг сэдвээр 61 удаагийн сургалтад АЕГ-ын албан хаагчдыг хамруулсан.

Арван гурав. Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах:

1. “ХЗДХЯ, АЕГ, ШШҮХ-ийн албан хаагчдыг орон сууцаар хангах төсөлд АЕГ, төрийн архивын 73 албан хаагчийг хамруулсан. АЕГ-ын 1 албан хаагчид Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар орон сууц олгосон.

2. Албан хаагчдыг зуслангийн газартай болоход дэмжлэг үзүүлж хамтран ажиллахыг хүсэж, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт АЕГ-ын 2018 оны 01/389, Нийслэлийн газрын албанд АЕГ-ын 2018 оны 01/485 тоот албан бичгээр хандаж шийдвэрлүүлсэн. Мөн Төв аймгийн Алтанбулаг сумын захиргаанд АЕГ-ын 2018 оны 01/508 тоот албан бичгээр хандаад байна.

3. “Төрийн байгууллагын архив, бичиг хэрэг хариуцсан ажилтны цалингийн сүлжээ, жишгийг нэмэгдүүлэх саналыг талаарх танилцуулга, санал”-ыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад АЕГ-ын 2018 оны 01/482 тоот албан бичгээр хүргүүлсний дагуу 2018 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 3/3240 тоот албан бичгээр төрийн албан хаагчийн албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэх ажлын хүрээнд санал, холбогдох мэдээллийг судалж үзэх тухай хариу ирүүлсэн.

4. Засгийн газрын 2006 оны 64 дүгээр тогтоолоор “Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн 4-р үе шат /2017-2020 он/-нд Үндэсний төв архив, төрийн архивуудад хадгалагдаж байгаа цаасан суурьтай баримт, кино, гэрэл зураг, дуу авианы баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх, цахим архив үүсгэх ажлыг зохион байгуулах гэрээгээр ажиллаж байсан 100 архивч-операторч нь Ажил гүйцэтгэх гэрээгээр ажиллаж байсныг АЕГ-ын даргын 2018 оны А/17, А/18 дугаар тушаалаар хугацаатай хөдөлмөрийн гэрээ байгуулж, хоол унааны зардлыг 2018.02.01-ний өдрөөс нэмэгдүүлэн ажлын өдрийн 5,000₮ болгосон. Хөдөлмөрийн хуулийн дагуу ээлжийн амралтыг ажилласан жилд ногдуулан олгосон.

5. АЕГ-т “Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтны мэргэшлийн “Ахлах” зэрэг горилж нийт 179 ажилтны ирүүлсэн баримт бичгийг нягталж, шаардлага хангасан бүрэн бүрдэлтэй баримтуудыг цэгцэлж, мэргэшлийн “Ахлах” зэргийн 92 үнэмлэхийг баталгаажуулж, холбогдох орон нутгийн төрийн архивт хүргүүлсэн.

6. Архивын ерөнхий газрын тушаалаар тус байгууллагын шагналаар Архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр ажиллаж буй 80 ажилтан шагнагдсан.

7. Албан хаагчдад ур чадвар 30,7 сая төгрөг, илүү цаг 15,3 сая төгрөгийн нэмэгдэл, 13 сая төгрөгийн буцалтгүй тусламж, 131,8 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон.

8. АЕГ-ын даргын 2018 оны А/89 дүгээр тушаалаар “АЕГ-ын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөл”-ийг 14 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан, ажлын байрны эрүүл, аюулгүй орчин нөхцөлийг бүрдүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр үүрэг хариуцлагыг дээшлүүлж, осол, эрсдэлээс ажилтан өөрийгөө болон бусдыг хамгаалах чадвар, дадлыг төлөвшүүлэх зорилготой ажиллаж байна.

9. АЕГ-ын байрны гадна, хаалга, цонхны дулаалга, барилгын гадна талын суурь хэсэгт хаяавч, дээвэр, шилэн ханын сийгэлтийг засварлах, хагарсан цонхнуудыг солих, цонхны хөшиг хийх, дулаан авахтай холбоотойгоор сантехникийн шугам хоолойг шалгах, өрөөнүүдийн агааржуулалт, чийг, дулааныг тэнцвэржүүлэх зэрэг ажлын байрны таатай нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажилласан. Мөн Архивын ерөнхий газрын гадна талбайд чацарганы 30 ширхэг, хар чавганы 15 ширхэг, бэсрэг алимны 15 ширхэг мод, “Агро-гарден сервис” ХХК-тай гэрээ хийж нарс 50 ширхэг, хус 30 ширхэг, гүйлс 20 ширхэг бургас 100 ширхэг, хайлаас 100 ширхэгийг тарьж, усалгаа арчилгаа хийн ажилласан ба гадна талбайн гэрэлтүүлэг хийлгэж, гадна орчныг тохижуулсан.

10. Засгийн газрын 2017 оны 112 дугаар тогтоолоор батлагдсан “Элэг бүтэн Монгол хөтөлбөрийн хүрээнд ХУД-ийн 10 дугаар хорооны “Амин тус” өрхийн эмнэлэгтэй хамтран байгууллагын 40-60 насны 15 ажилтныг хөтөлбөрт заагдсан шинжилгээнд хамруулж, гепатит В вирусийн эсрэг вакцинд хамруулсан. Мөн Сонгодо эмнэлэгтэй хамтран 106 албан хаагчийг элэгний В, С вирусийн шинжилгээнд хамруулсан.

11. 2018 оны 06 дугаар сарын 09-ний өдөр байгууллагын 40-өөс дээш насны 57 ажилтныг Хавдар судлалын үндэсний төвийн хавдраас урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулсан.

12. 2018 оны 12 дугаар сард Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэгт нийт албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулсан.

13. АЕГ-ын 5 дугаар давхарт ФИТНЕСС хэсэг гаргаж тохижуулж, шаардлагатай тоног төхөөрөмжийг байрлуулахаар ажиллаж байна.

14. Удирдлагын зөвлөлийн 2018 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдааны шийдвэрийн дагуу “Батзүү” ХХК-тай гэрээ байгуулан үйлчилгээний албан хаагчдын болон архивчдын хувцсыг хийлгэсэн.

Арван дөрөв. Төсөв, санхүүгийн үйл ажиллагааны хүрээнд:

1. Архивын ерөнхий газрын 2019 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2021 оны төсвийн төсөөллийг Сангийн яамнаас гаргасан төсвийн төсөл, дунд хугацааны төсвийн төсөөлөл бэлтгэх удирдамжийн дагуу бэлтгэн тайлбар тодруулгын хамт Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яаманд хүргүүлсэн.

2. Архивын ерөнхий газрын 2017 оны жилийн эцсээр санхүүгийн тайлан, санхүү үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, орлого үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, аккурэль суурьт шалгах баланс, төсвийн гүйцэтгэлийн тайлан, мөнгөн суурьт шалгах балансыг гарган тодруулгын хамт Үндэсний аудитын газраас томилогдсон “Стандарт аудит” ХХК-аар хянуулж, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд нь холбогдох хууль, /ОУНББОУС/ Улсын секторын нягтлан бодох, бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан загвар журмын дагуу материалыг алдаагүй үнэн зөв илэрхийлсэн, “Зөрчилгүй” санал, дүгнэлт гарсан. 2018 оны 12 дугаар сарын байдлаар улсын төсвөөс 3,150.1 сая төгрөг, өөрийн орлогоос 329.1 сая төгрөгийн санхүүжилттэй ажилласан. Сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг өглөг, авлагын тайлангийн хамт гаргаж байна. 2018 оны 12 дугаар сарын байдлаар 3,035.7 сая төгрөгийн гүйцэтгэлтэй ажилласан ба 115,0 сая төгрөгийн хэмнэлтийг тайлбарын хамт шилэн дансны цахим хуудсанд байршуулсан. Архивын ерөнхий газрын 2018 оны 1, 2, 3 дугаар улирлын санхүүгийн тайланг олон улсын стандартад нийцүүлэн гаргаж 2018 оны 02/149, 2018 оны 02/297, 01/478 тоот албан бичгээр ХЗДХЯ-нд хүргүүлсэн.

3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу Архивын ерөнхий газрын даргын 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А/13 дугаар тушаалаар “АЕГ-ын албан хаагчдын үйлчилгээний автобус нийлүүлэх” үнэлгээний хороог байгуулж, тендерийн баримт бичгийг боловсруулж, /тендерт

оролцох сонирхогчдод тавих шалгуур үзүүлэлт/, урилгыг “Өдрийн сонин, www.tender.gov.mn” цахим хуудсанд 2018 оны 03 дугаар сарын 16-ны өдөр байршуулж, нийтэд нээлттэй зарласан. Уг тендерт “ЖЕЙ ТИ ЭС ЭС” ХХК-аас өөр компани материал ирүүлээгүй ба тус компани нь тендерийн техникийн тодорхойлолтод заасан шалгуур үзүүлэлтийг хангасан тул “АЕГ-ын албан хаагчдын үйлчилгээний автобус нийлүүлэх” АЕГ/201812001 дугаар гэрээ байгуулагдсан. Гэвч нийлүүлэгч компани нь гэрээний үүргээ биелүүлээгүй буюу автобусыг гэрээний хугацаанд нийлүүлээгүй тул энэ тухай холбогдох байгууллагад мэдэгдэж, гэрээг цуцалсан.

АЕГ-ын даргын 2018 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн А/120 дугаар тушаалаар “АЕГ-ын албан хаагчдын үйлчилгээний автобус худалдан авах” үнэлгээний хороо дахин байгуулагдаж, холбогдох судалгаа хийж, техникийн тодорхойлолт, гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл тендерийн баримт бичгийг боловсруулж, удирдлагаар батлуулсан. 2018 оны 10 дугаар сарын 25-ны өдөр тендерийн баримт бичгийг өдөр тутмын хэвлэл “Өдрийн сонин, www.tender.gov.mn” сайтад байршуулан, сонгон шалгаруулалтыг нийтэд зарласан. Тендерийг 2018 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр нээсэн боловч тендерт нэг ч хуулийн этгээд оролцоогүй тул захиалагчид зөвлөмж хүргүүлсэн. Захиалагч зөвлөмжтэй танилцан автобус нийлүүлдэг аж ахуйн нэгжийг судалж 4-5 аж ахуйн нэгжид техникийн тодорхойлолт, үнийн саналыг ирүүлэх тухай албан бичиг хүргүүлэх чиглэл өгсний дагуу судалж нийт автобус нийлүүлдэг 8 ХХК-д албан бичиг хүргүүлсэн. Хариу ирүүлсэн байгууллагуудын саналтай танилцаж, Баганадант ХХК хамгийн сайн санал ирүүлсэн тул Үнэлгээний хорооны хурлаар гэрээ байгуулах тухай, шалгараагүй бусад байгууллагад шалгараагүй тухай албан бичгийг тус тус хүргүүлсэн. Гэрээний төслийг бэлтгэж, батлан Хууль зүй, дотоод хэргийн яамаар хянан баталгаажуулуулахаар холбогдох баримт бичгийн хамт 2018 оны 12 дугаар сарын 12-ны өдөр хүргүүлсэн. Тендерийн үр дүнгийн мэдээллийг www.tender.gov.mn сайтад байршуулсан.

Мөн хуулийн дагуу Архивын ерөнхий газрын даргын 2018 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/35 дугаар тушаалаар “Багаж тоног төхөөрөмж, лицензтэй программ хангамж худалдан авах” ажлын хэсэг байгуулагдаж, Архивын ерөнхий газрын 2018 оны бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах төлөвлөгөө /худалдан авах ажиллагааг тайлагнах журмын 1 дүгээр хавсралт/-ний дагуу 74 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч үндсэн хөрөнгийн орлогод бүртгээд байна.

АЕГ-ын даргын 2017 оны А/170 дугаар тушаалаар “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийг шинэчилж баталсан бөгөөд зөвлөлийн 2018 оны эхний хурлаар АЕГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй “Старекс” автомашиныг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай хамтран нээлттэй дуудлага худалдаагаар 4100000 төгрөгөөр худалдаж, төсөвт төвлөрүүлээд байна.

АЕГ-ын даргын 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн А/149 дүгээр тушаалаар “Бичгийн цаас, шатахуун нийлүүлэх этгээдийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо”-г байгуулж бичгийн цаас 11 сая, шатахуун 25 сая төгрөгөөр худалдан авах албан бичгийг байгууллагуудад хүргүүлсэн.

4. Шилэн дансны тухай хуулийн дагуу 5 сая төгрөгөөс дээш дүнтэй мөнгөн гүйлгээ, төсвийн зарлагын гүйцэтгэлийн мэдээ, аудитлагдсан тайлан, төсвийн хуваарь болон бусад холбогдох баримтуудыг шилэн дансны нэгдсэн систем болон www.archives.gov.mn сайтад байршуулсан. Үүнд: 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээнд 24 /давхардсан тоогоор/ удаагийн 325,1 сая төгрөгийн гүйлгээг хавсралт баримтуудын хамт байршуулсан. Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн талаарх мэдээнд хөдөлмөрийн чадвараа түр алдсан болон амаржсаны тэтгэмж авсан ажилтнуудын 42,5 сая төгрөгийн зарлагын гүйлгээг шилэн дансны цахим хуудас, www.archives.gov.mn сайтад байршуулсан.

Арван тав. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын чиглэлээр:

1. Архивын ерөнхий газрын 2017 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг Архивын ерөнхий газрын 2018 оны 01/44 тоот албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

2. Төрийн 36 архивын 2017 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн бөгөөд Төрийн архивын удирдах ажилтны зөвлөгөөнд илтгэл тавьж хэлэлцүүлж,

дүнг төрийн архивын харьяалах удирдлагуудад АЕГ-ын 2018 оны 01/185 тоот албан бичгээр хүргүүлсэн.

3. Хэрэглэгчийн үнэлгээг “Монголын хууль тогтоомжийн нийгэмлэг” ТББ-аар гүйцэтгүүлсэн бөгөөд үнэлгээний тайланг 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдөр АЕГ-т ирүүлсэн ба өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган, хэрэгжүүлж ажиллаж байна.

4. 2018 онд хийх Хяналт шалгалтын удирдамж, төлөвлөгөөг АЕГ-ын дарга баталж, холбогдох архивуудад АЕГ-ын 2018 оны 01/132 тоот албан бичгээр хүргүүлсэн. Үүний дагуу төрийн 7 архив, түүний хөмрөг, үүсгэгч 18 байгууллагад хяналт шалгалт явуулж, улсын байцаагчийн дүгнэлт, Дархан-Уул аймгийн Эрүүл мэндийн газар, Увс, Ховд аймгийн Засаг дарга, Орхон аймгийн Жаргалант сумын Засаг дарга нарт албан шаардлага хүргүүлсэн.

5. Таван байгууллага, аж ахуйн нэгжийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд хяналт шалгалт явуулах хяналт шалгалтын удирдамж, төлөвлөгөөг АЕГ-ын дарга баталж, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. Үүний дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, тэдгээрийн харьяа агентлаг, байгууллагуудад хяналт шалгалт явуулж, улсын байцаагчийн дүгнэлт хүргүүлсэн.

6. УБЕГ, ОӨГ, СБД-ийн ЗДТГ-ын хүсэлтийн дагуу Улсын бүртгэлийн нэгдсэн архивын байр, хадгаламжийн сан, баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөл байдалд, СХД-ийн ЗДТГ-ын Архивын тасаг, эд хөрөнгийн улсын бүртгэлийн баримтын хадгалалтын үйл ажиллагаанд, Оюуны өмчийн газрын архивын баримтын хадгалалт, хамгаалалт, тоо бүртгэлийн баримт бичгийн хөтлөлт, хадгаламжийн сангийн нөхцөл байдлын талаар тус тус хяналт шалгалт явуулж дүгнэлт хүргүүлсэн.

7. Архивын ерөнхий газрын төсөв санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх ажлын удирдамжийг АЕГ-ын дарга баталж, эргэлтийн хөрөнгөд дотоод аудит хийсэн. Дотоод аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

8. Үндэсний төв архивын Цахим сангийн төвийн үйл ажиллагаанд хяналт шалгалт явуулж, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан.

9. Нийслэлийн хэмжээнд ажиллаж буй архив, албан хэрэг хөтлөлтийн улсын хяналтын байцаагчдын Зөрчил шалган шийдвэрлэлтийн мэдээг гаргаж Нийслэлийн прокурорын газарт хүргүүлсэн.

10. Төрийн 36 архиваас 2017 оны үйл ажиллагааны тайлан, статистик мэдээг хүлээн авч, нэгтгэж, үнэлгээний дүн гаргасан бөгөөд Төрийн архивын удирдах ажилтны зөвлөгөөний үеэр танилцуулж, харьяалах удирдлагуудад АЕГ-ын 2018 оны 01/185 тоот албан бичгээр хүргүүлсэн. АЕГ-ын даргын 2017 оны А/144 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн архивын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-д заасны дагуу салбар, төрөлжсөн архив, аймаг, нийслэлийн архив гэсэн 2 ангиллаар төрийн архивуудын 2017 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгч, тусад нь байр эзлүүлэн дүгнэж, үнэлгээний дүнгээр эхний байранд орсон архивуудыг шагнаж урамшуулах ажлыг зохион байгуулсан.

11. Төрийн ба төрийн бус нийт 43 байгууллагын 348 нэр төрлийн хэвлэмэл хуудасны эхийг хянаж, хэвлүүлэх зөвшөөрөл олгосон.

12. “Үндэсний стандартын баримт бичгийн улсын үзлэг” явуулах тухай МУ-ын Ерөнхий сайдын 2018 оны 97 дугаар захирамжийн дагуу байгуулагдсан “Баримт бичгийн стандартын шинжлэх ухаан техникийн түвшингийн улсын үзлэг” хийх салбар комиссын гишүүнээр АЕГ-аас 2 албан хаагч томилогдон, 14 стандартын хэрэгжилтэд үнэлгээ хийж, дүгнэлт гарган хүргүүлсэн.

Арван зургаа. Албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлт, иргэд байгууллагатай байгуулсан гэрээний талаар:

1. Архивын ерөнхий газар нь 4119 албан бичиг хүлээн авсан ба үүнээс хариутай 3293, шийдвэрлэсэн 3292, хяналтад 1 байна. Үйл ажиллагааны явцад 1293 албан бичгийг гадагш илгээсэн.

2. Архивын ерөнхий газарт иргэн, байгууллагаас 880 өргөдөл, санал, гомдол ирсэн ба 868-ыг шийдвэрлэж, 12 нь шийдвэрлэх шатанд байна.

3. Тайлангийн хугацаанд иргэд, байгууллагатай нийт 44 гэрээ байгуулж ажилласан бөгөөд үүнээс 29 гэрээ бүрэн хэрэгжсэн, 14 гэрээ дараа онд үргэлжлэн хэрэгжихээр, 1 гэрээний хүрээнд тодорхой ажил хийгдээгүй байна.

**Арван долоо. “Төрийн албаны тухай хууль” тогтоомж, “Авлигын эсрэг хууль”,
“Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах,
ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийг
хэрэгжүүлэх хүрээнд:**

1. ЗГХЭГ-ын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2018 оны 265/72 дугаар хамтарсан тушаалаар баталсан удирдамжийн дагуу тус газрын төрийн жинхэнэ албан хаагчдын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлэх шалгалтад 20 албан хаагчийг хамруулж, шалгалтын багийнханд шаардлагатай мэдээ, тайланг гаргаж өгсөн.

2. Төрийн жинхэнэ албан хаагчийг томилох, сонгон шалгаруулахад Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйл, мерит зарчмыг мөрдлөг болгон ажиллаж байна. Үүнд: ТАЗ-ийн 2018.01.10-ны өдрийн 24 тоот албан бичгийн дагуу АЕГ-ын даргын Б/13 дугаар тушаалаар ЗУГ-ын ахлах мэргэжилтэн, 2018.02.07-ны өдрийн 138 тоот албан бичгийн дагуу АЕГ-ын даргын Б/20 тушаалаар МТХ-т мэргэжилтэн /түр/, ХЗДХЯ-ны дэргэдэх ТАЗ-ийн салбар зөвлөлийн 2018.10.12-ны өдрийн 17, 18 дугаар тогтоолыг үндэслэн АЕГ-ын даргын Б/140 тушаалаар ЗУГ-ын даргыг тус тус томилсон.

3. Төрийн захиргааны албан тушаалд анх томилогдсон 2 албан тушаалтныг АЕГ-ын даргын 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/156 дугаар тушаалаар төрийн жинхэнэ албан хаагчид хамааруулж, төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргүүлсэн.

4. Мэдээллийн технологийн хэлтсийн даргын албан тушаалын сонгон шалгаруулалтын захиалгыг 2018 оны 01/494 тоот албан бичгээр ХЗДХЯ-ны дэргэдэх Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлж, Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсанд сонгон шалгаруулалтын зарыг 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр байршуулсны дагуу АЕГ-ын цахим хуудасны ил тод цонхонд байршуулсан.

5. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 7.2.2-т заасны дагуу АЕГ-ын даргын 2018 оны А/13, А/120 дугаар тушаалаар байгуулагдсан “Ажилчдын үйлчилгээний автобус худалдан авах үнэлгээний хороо”-ны 10 гишүүний мэдүүлгийг гаргуулж цахим бүртгэл хөтөлсөн. Хуулийн 23.5-д заасны дагуу 2018 онд томилогдсон 8 албан тушаалтны урьдчилсан мэдүүлгийг бүртгэж АТГ-т хүргүүлэн, ирүүлсэн дүгнэлтийн дагуу томилсон. Хуулийн 24.2-т заасны дагуу 2017 оны ХАСХОМ /хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлэг/ мэдүүлсэн нийт 24 албан тушаалтны ХАСХОМ 1, 3 тайланг 2018 оны 01/67 тоот албан бичгээр АТГ-т хүргүүлсэн.

6. ХАСХОМ мэдүүлэх бүртгэлийн шинэчилсэн системийн баталгааны хуудасны дагуу бүртгэлийг цахимаар хийж цаасан хэлбэрээр АЕГ-ын 2018 оны 01/67 тоот албан бичгээр АТГ-т хүргүүлсэн.

7. Авлигатай тэмцэх газрын 2018 оны 03/8676 тоот албан бичгийн дагуу “Эс Ай Си Эй” ХХК-ийн “Төрийн байгууллагын авлигын индекс тодорхойлох судалгаа”-ны багийнханд шаардлагатай мэдээллийг өгч, өрөө тасалгаагаар хангаж ажилласан.

8. Байгууллагын 1, 2 давхрын мэдээллийн самбарт болон лавлагаа, үйлчилгээний хэсэгт “Шударга нийгмийн төлөө хамтдаа” гэсэн Авлигатай тэмцэх газраас гаргасан урьдчилан сэргийлэх мэдээлэл бүхий 4 төрлийн өнгөт хэвлэл байршуулсан.

9. Албан хаагчдад ЗГ-ын 2017 оны 326-р тогтоолоор шинэчлэн батлагдсан оффшор бүсийн жагсаалт болон хориглолт, хязгаарлалтыг зөвлөмж хэлбэрээр боловсруулж байгууллагын дотоод сүлжээгээр мэдээлсэн.

**Арван найм. Харьяа дээд шатны байгууллагаас өгсөн
үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангах чиглэлээр:**

1. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн А/46 дугаар тушаалаар батлагдсан “2018 оныг “Хариуцлагын жил” болгон зарлах тухай”

Засгийн газрын 2018 оны 32 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор төлөвлөгөөнд тусгах саналыг АЕГ-ын 2018 оны 01/88 тоот албан бичгээр, батлагдсан төлөвлөгөөний биелэлтийг 2018 оны 01/274 тоот албан бичгээр, жилийн эцсийн байдлаар нэгтгэж, 2018 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 01/590 тоот албан бичгээр тус тус ХЗДХЯ-нд хүргүүлсэн.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний биелэлтийг АЕГ-ын 2018 оны 01/275, 01/569 тоот албан бичгээр ХЗДХЯ-нд хүргүүлсэн.

3. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн А/91 дүгээр тушаалаар батлагдсан Хууль зүй, дотоод хэргийн салбарын “Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн дэд хөтөлбөр” /2018-2020/-ийн хүрээнд АЕГ-ын хэрэгжүүлсэн ажлын биелэлтийг АЕГ-ын 2018 оны 01/580 тоот албан бичгээр ХЗДХЯ-нд хүргүүлсэн.

4. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн шуурхай хурлаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг АЕГ-ын 2018 оны 01/440 тоот албан бичгээр хугацаанд нь хүргүүлсэн. ХЗДХЯ-аас АЕГ-ын 2017, 2018 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитын зөвлөмжийг хэрэгжүүлж, биелэлтийг заасан хугацаанд нь 09 дүгээр сарын 28-ны өдөр цахимаар болон АЕГ-ын 2018 оны 01/423 тоот албан бичгээр ХЗДХЯ-нд хүргүүлсэн.

Арван ес. Бусад ажлын талаар:

Архивын салбарын гавьяат үйлстнийг алдаршуулах чиглэлээр “Бидний бахархал” цуврал уулзалт, ярилцлагыг зохион байгуулж МУ-ын Соёлын гавьяат зүтгэлтэн, ахмад архивч Г.Норовсамбуу, МУ-ын Соёлын гавьяат зүтгэлтэн, ахмад архивч О.Энхмөнх, МУ-ын Төрийн соёрхолт, түүхч, доктор Д.Өлзийбаатар нарыг 2018 оны 09 дүгээр сарын 28, 11 дүгээр сарын 17, 12 дугаар 05-ны өдрүүдэд тус тус хүлээн авч, хүндэтгэл үзүүлсэн.

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР